



УЛААНХУС СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Тэргүүлэх аудитор
М.Хуанган
Утас:70422954
Цахим хаяг:

Аудитын менежер:
Х.Женисбек
Утас: 70422930
Цахим хаяг:

Аудитор: Х.Манаргүл
Утас:95429524
Цахим хаяг:

Хаяг: Баян-Өлгий аймаг дахь
Төрийн аудитын газар

Байршил: Өлгий сум, 5-р баг,
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р
давхар

Цахим хуудас: www.bayan-ulgii.gov.mn

2018 оны 3 дугаар сар

Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээ тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын баталсан холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 15-наас 3 дугаар сарын 23-ны хооронд хийхээр төлөвлөн аймаг дах Төрийн аудитын газрын ахлах аудитор Х.Манаргүл хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад 2018 оны 03-р сарын 02-ны өдрийн №1/63-р албан бичгээр 3 дугаар сарын 05-нд ирүүлсэн.

Баян-Өлгий аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 16-наас 3 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 26-нд Улаанхус сумын Засаг даргад гардуулав.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Татварын багц хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь “Төрийн бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, мэргэшсэн, мэдлэг чадвар бүхий боловсон хүчнээр эгнээгээ бэхжүүлж, төрийн ёс зүйг чандлан сахиж, нутгийн иргэдийн эрх ашгийг дээдлэн төрийн үйлчилгээг шударга ил тод, шуурхай нээлттэй хүргэж ажиллана” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагаагаа эрхлэн гүйцэтгэж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу гэж Улаанхус сумын Засаг дарга нь төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. 2017 оны төсвийг орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаар дамжуулан Улаанхус сумын төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 27-ийг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа программын үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэлгүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан тэмдэглэл тодруулга, бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Пластик”, “Аколоус” програм хангамж ашиглажээ.

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Улаанхус сумын Төсвийн

төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “бага” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

6.1. Орлого, татаас санхүүжилтийн талаар:

6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлангаар тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 4482,1 сая төгрөгийн санхүүжилт, 14,4 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 298,5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 107,3 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Нэмэлт санхүүжилтээр 12,9 сая төгрөг хүлээн авчээ.

6.1.3 Үндсэн үйл ажиллагааны орлого

Улаанхус сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагаанаас 1,0 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 0,3 сая төгрөгийн орлого оруулж, 0.7 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

6.1.4 Орон нутгийн татварын орлого

Улаанхус сумын ИТХ-аас сумын 2017 оны Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 95,6 сая төгрөгөөр баталжээ. Орлогын бүтцийг авч үзвэл нийт орлогын 17,4 хувийг ХАОАТатвараас, 7,1 хувийг өмчийн татвараас, 75,5 хувийг бусад татвараас оруулахаар төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал: /мян төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Нийт орлого	95,630.2	107,311.7	11,681.5	112.2

I.Татварын орлого	95,630.2	105,847.5	10,217.3	110.7
ХАОАТатвар	16,650.0	34,354.8	17,704.8	206.3
Өмчийн татвар	6,809.5	5,777.5	- 1,032.0	84.8
Бусад татвар	72,170.7	65,715.2	- 6,455.5	91.1
II.Татварын бус орлого	-	1,464.2	1,464.2	-

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 107,3 сая төгрөгийн орлого төвлөрүүлж төлөвлөгөөг 11,7 сая төгрөгөөр буюу 112,2 хувиар давуулан биелүүлжээ. Нийт орлогын 98,6 хувийг татварын орлогоос, 1,4 хувийг татварын бус орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатварыг 17,7 сая төгрөгөөр буюу 206,3 хувиар давуулан биелүүлж, өмчийн татвар 1,0 сая төгрөгөөр буюу 15,2 хувиар, бусад татвар 6,5 сая төгрөгөөр буюу 8,9 хувиар тасарчээ. ХАОАТ-ын орлогыг 17,7 сая төгрөгийн орлогыг төлөвлөснөөс илүү оруулсан нь төлөвлөгөө нийт дүнгээр давж биелэгдэхэд гол нөлөө үзүүлжээ.

Орон нутгийн ерөнхий орлогын 910 тоот дансанд оны эхэнд 16,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба Орон нутгийн орлогын 995 тоот дансаар 107,3 сая төгрөгийн татварын орлого оруулж, оны эцэст орон нутгийн төсвийн ерөнхий орлогын 910 тоот дансанд 17,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

Сумын төрийн сан дахь цалин хөлсний татварын орлогын 901 тоот дансаар нийтдээ 287.8 сая төгрөгийн орлогыг оруулж, аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Сумын төсөвт байгууллагуудаас төлсөн цалин хөлсний татварын орлогыг тухай бүр аймгийн ЦХТОрлогын дансанд төвлөрүүлж ажилласан байна. Газрын төлбөрөөс 1.3 сая төгрөгийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

6.1.5 Бусад орлого

Тайланд онд Орон нутгийн хөгжлийн санд 76,6 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 60,6 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн санд 13,2 сая төгрөгийн орлого оруулсан байна.

6.2. Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:

6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 5255,2 сая төгрөгийн төсөв батлагдсаны 4482,1 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 388,3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 76,6 сая төгрөгийг ОНХСангаас, 291,5 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, 16,7 сая төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тусгажээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 4481,5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 458,8 сая төгрөгийн, ОНХСангаас 76,6 сая төгрөгийн санхүүжилтийг авч, үйл ажиллагааны орлогоос 74,2 сая төгрөг, урьд оны үлдэгдлээс 16,6 сая төгрөг бүрдүүлж бүгд дүнгээр 5031,1 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан төсвөөс нийт дүнгээр 224,1 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ. Энэ нь Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төлөвлөсөн орлого бүрдээгүй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.
/сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /мөнгөн дүнгээр/	Зөрүү /Хувиар/
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	5,255.2	5,031.2	224.0	95.7
1.1	Урсгал зардал	5,255.2	5,031.2	224.0	95.7
2	Зардлыг сахүүжүүлэх эх үүсвэр	5,255.2	5,031.2	224.0	95.7
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	4,482.1	4,481.5	0.6	100.0
2.2	Орон нутгийн төсвөөс	388.3	382.2	6.1	98.4
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	76.6	76.6	-	100.0
2.4	СХСангаас	290.5	60.6	229.9	20.9
2.5	Урьд оны үлдэгдлээс	16.7	16.7	-	100.0
2.6	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	1.0	13.6	- 12.6	1,360.0

Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал: /сая төгрөг/

Төсөвт байгууллагуудын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
Сумын ИТХурал	60.6	60.6	-	100.0
Сумын ЗДТГазар	378.5	382.1	3.6	101.0
Ахлах сургууль	1,489.9	1,489.9	0.0	100.0
Хөххөтөл ДСургууль	945.2	945.2	-	100.0
Согоог ДСургууль	695.5	695.2	- 0.3	100.0
ЭМТөв	536.9	536.6	- 0.3	99.9
Хүүхдийн цэцэрлэг	366.9	366.9	-	100.0
Хөх хөтөл хүүхдийн цэцэрлэг	173.0	173.0	-	100.0

Согоог хүүхдийн цэцэрлэг	224.4	224.4	0.0	100.0
Соёлын төв	51.4	50.7	- 0.6	98.7
ОНХСан	42.4	35.5	- 6.9	83.7
СХСан	290.5	51.3	- 239.2	17.7
ДҮН	5,255.2	5,011.4	- 243.8	

Сумын төсөвт байгууллагууд батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна. /сая төгрөг/

Тайлант оны

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,255.1	5,024.60	230.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,991.77	2,991.77	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	327.40	327.40	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	392.58	391.99	0.59
Хангамж, бараа материалын зардал	87.73	87.70	0.03
Нормативт зардал	503.12	503.10	0.02
Эд хогшил, урсгал засварын зардал	16.22	16.22	-
Томилолт, зочны зардал	9.27	9.27	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51.46	51.45	0.01
Бараа үйлчилгээний бусад зардал	325.67	109.38	216.30
Урсгал шижүүлэг	507.48	500.79	6.69
Хөрөнгийн зардал	42.44	35.52	6.92

6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 27,2 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд 27,2 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

6.2.3 Сангуудын зарцуулалт

Улаанхус сумын ОНХСан нь оны эхэнд үлдэгдэлгүй гарсан ба тайлант онд 76,6 сая төгрөгийн санхүүжилт авч, 42,4 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд, 34,2 сая төгрөгийг МЭҮАХ-ний зардалд зарцуулж, оны эцэст 6,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд үлдэгдэлгүй гарсан ба, тайлант онд эргэн төлөлтөөс 60,6 сая төгрөгийн орлогыг оруулж, 51,3 сая төгрөгийн зээл олгож оны эцэст 9,3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. СХСан нь жилийн эцэст 387,2 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан харилцах данс оны эхэнд 0.04 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд 13,2 сая төгрөгийн орлого оруулж, 13,2 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 0,05 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,6	34,1
Кассанд байгаа бэлэн мөнгө	9,8	0,05
Төгрөг	9,8	0,05
Банкинд байгаа бэлэн мөнгө	16,9	34,0
Төгрөг	16,9	34,0
Төрийн сангийн харилцах	16,9	34,0

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 26,6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0.05 сая төгрөг нь касс, 34,0 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Төрийн сан дахь харилцах дансны үлдэгдлийн 17,8 сая төгрөг нь Орон нутгийн ерөнхий орлогын, 9,3 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сангийн, 6,9 сая төгрөг нь ОНХСангийн дансны үлдэгдэл байна.

6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
АВЛАГА	314.9	390.1	75.2
Татаас, санхүүжилтийн авлага	15.9		-15.9
Бусад авлага	3.6	2.9	-0.7
Байгууллагаас авах авлага	1.6	0.9	-0.7
Хувь хүмүүсээс авах авлага	2.0	2.0	0
Зээлийн авлага	295.4	387.2	91.8
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	295.4	387.2	91.8
Хувь хүмүүст олгосон зээл	295.4	387.2	91.8

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 75,2 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Санхүүгийн албанаас сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагын өмнөх оны үлдэгдлийг харилцагч бүрээр тооцоо хийж, зээлийн хүү болон үлдэгдлийг баталгаажуулж, залруулга хийсэнтэй холбоотой үлдэгдэл оны эхнээс 91,8 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна. Сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагыг тооцоо нийлж, зээлдэгч нэг бүрээр тооцоон баталгаажуулж зарим харилцагч нарыг хуулийн байгууллагад шилжүүлэн өр барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
БАРАА МАТЕРИАЛ	381,7	432,8	51,1
Түүхий эд материал	4,2	6,1	1,9
Хангамжийн материал	367,6	416,8	49,2
Мал амьтад	9,9	9,9	0,0

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 51,1 сая төгрөгөөр өссөн байна. Бараа материалын бүтцийг авч үзвэл 1,4 хувь нь түүхий эд материал, 96,3 хувь нь хангамжийн материал, 2,3 хувь нь мал амьтад эзэлж байна. Тайлант онд нийтдээ 7,4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал /сая төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12511,1	13121,7	610,6
391	Газар			0,00
392	Биет хөрөнгө	12504,8	13115,5	610,6
393	Биет бус хөрөнгө	6,3	6,3	0,0

Үндсэн хөрөнгө оны эхнээс 610,6 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд 13,3 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 686,2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, 18,5 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

Тайлант онд төсөвт байгууллагууд нийтдээ 686,2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГазар нь 2,5 сая төгрөгийн, Бүрэн дунд сургууль 11,8 сая төгрөгийн, Хөх хөтөл ДСургууль 3,5 сая төгрөгийн, Согоог ДСургууль 78,9 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 1,8 сая төгрөгийн, Хөх хөтөл Хүүхдийн цэцэрлэг 587,4 сая төгрөгийн, Соёлын төв 0,4 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авсан байна. Тайлант онд 68,3 сая төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан байна.

2017 онд 18,5 сая төгрөгийн тээврийн хэрэгслэлийг шилжүүлэн авч, 39,1 сая төгрөгийн үнэ бүхий барилга байгууламж, авто тээврийн хэрэгслийг балансаас балансад шилжүүлсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгөнд 317,6 сая төгрөгийн элэгдэл тооцсон байна.

6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

		/сая төгрөг/	
НИЙТ ӨР ТӨЛБӨР	55.60	52.80	(2.80)
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	55.60	52.80	(2.80)
Өглөг	55.60	52.80	(2.80)
Ажилчидтай холбогдсон өглөг	2.20	26.00	23.80
Бараа үйлчилгээний зардлын өглөг		0.70	0.70
Бусад өглөг	53.40	26.20	(27.20)
Байгууллагад төлөх өглөг	53.40	24.90	(28.50)
Хувь хүмүүст төлөх өглөг		1.20	1.20

Оны эцэст ЗДТГазар 1,6 сая төгрөгийн, ИТХурал 0.1 сая төгрөг төгрөгийн, Ахлах сургууль 18,4 сая төгрөг төгрөгийн, Хөх хөтөл Дунд сургууль 12,8 сая төгрөгийн, Согоог дунд сургууль 2,2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн төв 8,6 сая төгрөгийн, сумын Хүүхдийн цэцэрлэг 5,9 сая төгрөгийн, Хөх хөтөл Хүүхдийн цэцэрлэг 0,5 сая төгрөгийн, Согоог Хүүхдийн цэцэрлэг 0,8 сая төгрөгийн, Соёлын төв 0.3 сая төгрөг төгрөгийн, ОНХСан 1.6 сая төгрөгийн нийтдээ 52,8 сая төгрөгийн өглөгтэй гарчээ.

6.3.6 Цэвэр хөрөнгө/өмчийн талаар

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн нийт дүн 9562,7 сая төгрөг буюу ЗГОКапитал 4255,6 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1843,7 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 3463,4 сая төгрөг байна. Тайлант онд 429,5 сая төгрөгийн үр дүнтэй ажилласан байна.

Долоо. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангаж ажиллах зорилгоор shilendans.gov.mn цахим хуудсанд 2017 оны мэдээлэлээ бүрэн байршуулжээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд 2017 онд хийсэн нийцлийн аудитаар Улаанхус сумын төсөвт байгууллагуудад Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгуулах албан шаардлага өгсөн ба 2017.12.22-нд №1/299 тоотын дагуу 5009,7 сая төгрөгний зөрчлийн биелэлтийг ирүүлсэн байна.

Найм. Аудитын дүнгийн талаар

8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний Орон нутгийн орлогын бүртгэл, тайлагнал, санхүүжилтийн эх үүсвэр, гүйцэтгэл, төсөвт байгууллага, сангуудын санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг нэгтгэх, тулган баталгаажуулах зэргээр ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой материаллаг алдаа зөрчил илрээгүй ба аудитаар материаллаг бус дараах алдаа, зөрчил илрэв. Үүнд:

1. Сумын төрийн сан Бүрэн дунд сургууль 7,1 сая төгрөгийг, Согог дунд сургууль 6,9 сая төгрөгийг, Улаанхус хүүхдийн цэцэрлэг 3,9 сая төгрөгийг, Хөххөтөл цэцэрлэг 1,1 сая төгрөгийг, Согог хүүхдийн цэцэрлэг 6,4 сая төгрөгийг бүгд 25,4 сая төгрөгийг хоолны зардлын 2017 онд батлагдсан төсвөөс бага үнэтэй түргэн элэгдэх зүйл худалдан авахад аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн сангийн зохих зөвшөөрөлгүйгээр гүйлгэн зарцуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 42.3, 42.4 дэх заалтууд болон Сангийн сайдын 2013 оны "төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам"-ын 5.2-т "аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь төсвийн захирагчаас ирүүлсэн саналыг судлан үзээд зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд тухайн зардлын бүлгийн батлагдсан төсвийн жилийн дүнгийн 120 хувиас хэтрэхгүй, 10.0 сая төгрөг хүртэлх зохицуулалтыг хийж...баталгаажуулна" гэсэн гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: *Сумын ТТЗ-ын тайлангаар зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.*

2. Засаг даргын тамгын газрын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй байсан 7 ажилтанд Засгийн газраас олгосон 300000 төгрөгийн нэг удаагийн мөнгөн урамшуулалыг

олгож, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас жилийн чөлөө авсан нэг ажилтанд олгогдоогүй 300.0 мян төгрөгийг НДШимтгэлд шилжүүлж зориулалт бус шилжүүлж, ЗДТГазрын 3 дугаар сарын цалингийн хүснэгтээр гарт олгох дүнгээс 59.7 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн байна

Шийдвэрлэсэн нь: *Зориулалт бус шилжүүлсэн төсвийн хөрөнгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоов.*

3.2017 оны төсөвт орон тооны хязгаарыг 411,5-аар баталсан ба гүйцэтгэлээр 435 орон тоог ажиллуулж, 24,5 орон тоог илүү ажиллуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: *Аймгийн ТЕЗ-ийн СНТайлангаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.*

8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй.

8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитын дүнгийн талаар

Улаанхус сумын Сумын ИТХурал, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, Бүрэн дунд сургууль, Хөх хөтөл Дунд сургууль, Согоог Дунд сургууль, Эрүүл мэндийн төв, сумын Хүүхдийн цэцэрлэг, Хөх хөтөл Хүүхдийн цэцэрлэг, Согоог Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайлан, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд бие даасан дүгнэлт гаргалаа.

Сумын Засаг даргын тамгын газар, ОНХСан, Сум хөгжүүлэх сан, Эргэлтийн эмийн сангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Аудитын үр дүнг хүснэгтээр нэгтгэн харуулбал:

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс Зөрчилгүй санал дүгнэлт
Улаанхус сумын ЕБСургууль	8,7	1	1
Улаанхус сумын Согог дунд сургууль	7,3	1	1
Улаанхус сумын Хүүхдийн цэцэрлэг	4,2	1	1
Улаанхус сумын Согог цэцэрлэг	6,4	1	1
Улаанхус сумын Хөххөтөл цэцэрлэг	1,1	1	1
Баяннуур сумын ЗДТГазар	1,9	1	1
Улаанхус сумын ЗДТГазар	11,6	1	1
Улаанхус сумын Хөх хөтөл дунд сургууль	12,8	1	1
ТТЗ-ийн СНТ		1	1
Дүн	54,0	8	8

8.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Улаанхус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ... хуудас хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.ХУАНГАН
Огноо:2018.03.29

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

Огноо:2018.03.29

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Х.МАНАРГҮЛ
Огноо:2018.03.29

